БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, СОЁЛ,
СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН САЙД

.....Ч.УНДРАМ

АТА12931 6594204 9024070548

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6 дугаар бүлгийн "Ногоон хөгжил"-д "Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах", "Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх", "Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэх, нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах" зорилтуудыг дэвшүүлж, зорилт тус бүрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.5-д заасан "Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал"-ын тодорхойлолтод "Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдолоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн" гэж заажээ.

Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлсон зорилтын хүрээнд байгальд ээлтэй байх, байгалийн унаган төрх, үзэмжит байдлыг хамгаалах, байгалийн нөөц, баялгийг зохистой ашиглах, байгаль орчны доройтлоос сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, байгаль орчныг хамгаалах уламжлалт мэдлэг, арга ухааныг түгээн дэлгэрүүлэх, байгалийн өвийг сурталчлах зэрэг агуулгатай хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Аж үйлдвэрлэл, технологийн үсрэнгүй хөгжлийг даган байгаль орчинд үзүүлж буй хүний буруутай үйл ажиллагааны нөлөөгөөр дэлхийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээтэй тэнцвэрт байдал алдагдаж, хүн төрөлхтний өмнө урьдчилан тааварлахын аргагүй олон сорилт, бэрхшээл, эрсдэл учирч байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай үер, түймэр, хөрсний гулсалт, цунами, ган, зуд, элсний нүүдэл зэрэг байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн давтамж өсөн нэмэгдэж, хүрээлэн буй орчин, хүний амь нас, эрүүл мэнд, амьдралын чанар болон эдийн засагт асар их хор хохирол учруулах болов. Дэлхийн цаг уурын байгууллага (WMO)-ын 2025 оны урьдчилсан тайланд "сүүлийн 50 жилд уур амьсгалтай холбоотой гамшгийн тоо 5 дахин өсөж, 2024 онд гамшигт өртөн 18.000 орчим хүн нас барж, 150.000.000 сая хүнд нөлөөлж, эдийн засагт 387.0 тэрбум долларын хохирол учруулсан"-ыг мэдээлжээ. Түүнчлэн, эрдэмтэд уур амьсгалын нөлөөгөөр ойрын жилүүдэд 1 сая орчим амьтан, ургамлын зүйл устах эрсдэлтэй байгааг анхааруулж байна. Дэлхийн улс орнууд дээрх гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хохирлыг арилгах зорилгоор ихээхэн хүчин чармайлт гаргаж, Тогтовортой хөгжлийн зорилт 2030, Парисын хэлэлцээр зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрийг батлан тодорхой зорилтот түвшин рүү тэмүүлж, хамтын хүчээр сөрөн зогсож байгаа ч хүн төрөлхтөнд учруулж буй хохирлыг бууруулж чадахгүй байна.

Дэлхийн болон үндэсний хэмжээний дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд шинжлэх ухаан, байгаль орчны тухай мэдлэг, боловсрол, үзэл санааг түгээн дэлгэрүүлэх чиглэл бүхий соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа онцгой ач холбогдолтой. Ялангуяа байгаль орчныг танин мэдэх, хамгаалах бодлого, зорилтыг цогцоор нь хэрэгжүүлэхэд байгалийн музейн үүрэг оролцоо чухал. Юмс, үзэгдлийн бүрэлдэн тогтох учир шалтгаан, түүний хувьсан өөрчлөгдөх зүй тогтол, төлөв байдал, устах үйл явц, хамгаалал зэрэг ойлголт, мэдлэгийг цуглуулгад түшиглэн техник технологийн тусламжтай цогц байдлаар дэглэсэн үзүүллэг, олон талт үйл ажиллагаагаар бүх нийтэд ойлгуулах боломжтой соёлын орон зай бол музей мөн.

ЮНЕСКО-ийн 2015 оны Ерөнхий бага хурлаас батлагдсан "Музей болон цуглуулгыг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх ба тэдгээрийн олон янз байдал, нийгэм дэх үүргийн талаарх зөвлөмж"-д "Соёлын болон байгалийн, биет болон биет бус, хөдлөх болон үл хөдлөх өвийг хадгалах, судлах, дамжуулах нь улс орнуудын яриа хэлэлцээр, нийгмийн нэгдмэл байдал, тогтвортой хөгжил болон нийгэмд бүхэлдээ ихээхэн ач холбогдолтой" болохыг дурдаад "музей нь соёлын түгээлт, соёл хоорондын харилцан яриа, хэлэлцүүлэг, сургалтын орон зай болохоос гадна боловсрол (албан, албан бус, насан туршийн сургалт), нийгмийн эв нэгдэл, тогтвортой хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг ба үүний зэрэгцээ олон нийтийн соёл, байгалийн өвийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, түүнийг хамгаалах, өвлүүлэх хариуцлагыг ухамсарлуулахад ихээхэн үүрэг"-тэй болохыг тодорхойлжээ.

Байгалийн юмс, үзэгдлийн бүрэлдэн тогтох учир шалтгаан, түүний хувьсан өөрчлөгдөх зүй тогтол, төлөв байдал, устах үйл явц зэрэг ойлголт, мэдлэгийг бүх нийтэд цуглуулга, техник технологийн тусламжтай цогц байдлаар дэглэсэн үзүүллэгээр ойлгуулах, мэдрүүлэх, соёлын орон зай бол музей мөн. Музейн энэхүү онцлогийг харгалзан хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй байгаль орчны олон талт асуудал тухайлбал, байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн давтамж, хор хөнөөлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дэлхий дахины зорилгод нэгдэн, хувь нэмрээ оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

ATA12932 6594204 9624070546

Монгол оронд байгалийн цуглуулгыг бүрдүүлэх, олон нийтэд сурталчлах ажил 1920-иод онд Судар бичгийн хүрээлэн (1921-1930) байгуулагдсанаар тавигдсан. 1926 онд Богд хааны өвлийн ордонд байгуулсан музейн байгалийн түүхийн хэсэгт эрдэс, чулуулаг, палеонтологийн олдворууд, хөрс, ургамал, амьтны цуглуулгыг дэглэн нийтэд үзүүлж байжээ. 1956 онд байгуулагдсан Улсын төв музейн сан хөмрөгийг Монгол орны нутагт тархсан ургамал, амьтны зүйлүүдийн цуглуулгаар баяжуулан, байгалийн үзүүллэгийн танхимыг тусгайлан дэглэж иргэдэд үйлчилж байсан бол 1991 онд Байгалийн түүхийн музей байгуулагдаж, Монгол орны төдийгүй дэлхийд ховордсон ургамал, амьтны зүйлийн цуглуулга, эрдэс чулуулгийн дээж, палеонтологийн олдворуудаар сан хөмрөгөө баяжуулж ирсэн түүхтэй.

Цаашид музейд орчлонгийн үүслээс эхлээд амьдралын үүсэл, хувьсал, Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн онцлогийг тодотгон харуулсан цуглуулга, үзүүллэгээр шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдлэгийг бүх нийтэд хүртээмжтэй, чанартай, олон хэлбэрээр хүргэх, байгалийн шинжлэх ухааны сургалт, судалгааг бие даан, бусад байгууллага, судлаачидтай хамтран гүйцэтгэх, улс орны нийгэм, эдийн засагт бодит нөлөө үзүүлэхүйц Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей болгон хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор урган гарав.

ХОЁР. МУЗЕЙН ТӨРӨЛ

Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей нь байгалийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн шүтэлцээт харилцаа, хувьсал, өөрчлөлтийн шинж чанар, зүй тогтлыг илэрхийлсэн шинжлэх ухааны ач холбогдолтой үнэ цэнтэй цуглуулга, дэвшилтэт технологи, инновацад суурилсан үзмэр, үзүүллэг бүхий нийгэмд чиглэсэн олон нийтийн оролцоотой соён гэгээрэл, албан бус боловсролын үйлчилгээ эрхэлдэг, үндэсний хэмжээний боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага байна. Тус музей нь төрийн өмчит, үндэсний зэрэглэлтэй байна.

Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн алсын хараа “Эрдэм шинжилгээ, инновац, боловсрол, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан Монгол орны байгаль, нийгэм, соёл, түүхийн өвийг дэлхийн шинжлэх ухааны нээлтийн салшгүй хэсэг болгосон Азийн тэргүүлэх байгалийн шинжлэх ухааны музей болно” гэж, харин эрхэм зорилгыг “Байгаль, соёлын өвийг судлах, хамгаалах, цуглуулах, хадгалах, сурталчлах арга замаар байгаль орчны боловсрол, тогтвортой хөгжил, насан туршийн суралцахуй, олон улсын хамтын ажиллагааг дэмжсэн, Монголын онгон байгалийн өвийг онцлон таниулсан эрдэм шинжилгээ, боловсрол, мэдлэгийн төв болон хөгжинө” хэмээн тодорхойлж байна.

ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей Монгол Улсын Музейн тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасан үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ба “үндэсний” зэрэглэлтэй музейн хувьд дараах үйл ажиллагааны чиглэлийг баримтална. Үүнд:

1.Монгол орны байгалийн шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэ цэнтэй цуглуулгаар сан хөмрөгөө бүрдүүлэх, байгалийн хувьсал, өөрчлөлт,

ATA12932 6594204 9074070546

хөгжлийн үйл явц, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг онол, практикийн өндөр түвшинд судлах, нийтэд шинжлэх ухааны мэдлэг дамжуулах нь музейн үндсэн чиглэл юм.

2.Дэвшилтэт технологи, инновацад тулгуурлан эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлж, олон талт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3. Олон улс, бүс нутгийн байгууллагын сүлжээнд нэгдэж, хамтын ажиллагааг өргөн хүрээнд системтэй өргөжүүлнэ. Шинжлэх ухааны үнэ цэн бүхий байгалийн цуглуулгын төрөлжсөн мэдээллийн сан бүрдүүлнэ. Биологийн төрөл зүйлийн мониторингийн судалгааны түшиц газартай байна.

4.Эрдэм шинжилгээ, боловсролын байгууллагуудтай хамтарсан урт, дунд богино хугацааны эрдэм шинжилгээ, боловсрол, инновац, технологийн зэргийн бус сургалт, хурал, семинар, зөвлөгөөн зохион байгуулах, боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжилтэн, судлаач, ажилтан солилцох үйл ажиллагааг эрхэлнэ.

5.Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын судлаач, суралцагчдын онол, практикийн судалгаа, сургалтын түшиц байгууллага байх бодлогыг дэмжинэ.

6.Монгол орны байгалийн шинжлэх ухааны судлагдахуун, түүний бүрэлдэхүүн, бүтэц, үүсэл, хөгжил, өөрчлөлт, шүтэлцээт харилцааны зүй тогтлыг илэрхийлсэн иж бүрэн, цогц агуулгыг шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан үзэгдийн сонирхолд нийцүүлсэн, оролцоог хангасан үзүүллэг, үзэсгэлэнгээр үйлчилж, олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулна.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Музей нь соёл, шинжлэх ухаан, албан бус боловсролын байгууллагын хувьд дотоод, гадаадын олон талт түншлэлд тулгуурлан үйл ажиллагааны дараах хүрээг хамран ажиллана. Үүнд:

1.Дотоод, гадаадын эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага, төр, төрийн бус, бизнесийн байгууллага, ЮНЕСКО болон Олон улсын музейн зөвлөл, дэлхийн тэргүүлэх байгалийн шинжлэх ухааны музей, олон улсын бусад байгууллага, судлаач, мэргэжилтэн, шинжээч, иргэдтэй түншлэл тогтоож, туршлага солилцох, хүний нөөцийг бэхжүүлэх, хамтарсан судалгаа, үзэсгэлэн, хөтөлбөр хэрэгжүүлэх арга замаар олон улсын хамтын ажиллагааны идэвхтэй оролцогч байна.

2.Монгол орны байгаль орчин, тэдгээрийн бүтэц, бүрэлдэхүүн, тогтолцоо, биологийн олон янз байдлын хомсдол, уур амьсгалын өөрчлөлтийн санаачилга, судалгаа, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, мэдлэг солилцох, судалгааны үр дүнг олон нийтэд түгээх платформыг хөгжүүлэх, тэдгээрийг дижитал инновац, боловсрол, соёлын судалгаатай уялдуулсан бүтээлч, соёл хоорондын солилцоог шүтсэн шинжлэх ухаан, бодлогын хэлэлцүүлгийн нээлттэй орон зай болгон хөгжүүлнэ.

ATA12932 6594204 9024070546

ТАВ. ЦУГЛУУЛГЫН БОДЛОГО

Музейн сан хөмрөгийг байгалийн шинжлэх ухааны ач холбогдол, үнэ цэн бүхий цуглуулгаар системтэй баяжуулна.

Үзмэр цуглуулгатай холбоотой бүхий л үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, хэлэлцээр болон Олон улсын музейн зөвлөлийн ёс зүйн дүрэмд нийцүүлж, чанд мөрдөнө.

Музейн үзмэр цуглуулгыг хууль, эрх зүйн хүрээнд бүрдүүлэх, бүртгэх, хадгалан хамгаалах, дотоод, гадаадын холбогдох музей болон эрдэм шинжилгээний бусад байгууллагуудтай солилцох, судлах, ашиглах, хамтарсан үзэсгэлэн зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэн буцаан шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг ил тод, хариуцлагатайгаар хэрэгжүүлнэ.

Цуглуулгын иж бүрэн цахим мэдээллийн санг бүрдүүлэх урт хугацааны стратегийг хэрэгжүүлж, Монгол Улс, олон улсын судлаачид, боловсролын байгууллагууд, олон нийтэд нээлттэй, ёс зүйтэй ашиглах боломжийг үе шаттайгаар бүрдүүлж, дэвшилтэт технологи, инновац шингээсэн шинэ арга зүйд тулгуурлан цуглуулгыг баяжуулах, үзүүллэг дэглэлтийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ҮЗҮҮЛЛЭГИЙН БОДЛОГО

Музейн үзүүллэгийн бодлого нь орчлон ертөнцийн үүслээс эхлэн амьдралын хувьсал, хүн төрөлхтний хөгжил, Монгол орны геологийн тогтоц, биологийн олон янз байдлын онцлог хүртэл логик уялдаа холбоотой, үзэгчийн аяллын цогц орчныг бүрдүүлэхэд чиглэнэ. Үүнд:

1.дэлхий, түүний бүрэлдэхүүн хэсгийн үүсэл, хөгжил, өөрчлөлтийн зүй тогтол;

2.монгол орны геологи, газарзүйн онцлог, улирал, байгалийн өвөрмөц тогтоц, ус, намгархаг газар, дэлхийн өвд "хосолмол" болон "байгалийн" ангиллаар бүртгэгдсэн дэлхий дахины хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий газар нутаг;

3.амьдралын үүсэл, хувьсал, хөгжлийн түүхийг илтгэх эртний амьтан, ургамлын чулуужсан үлдвэр;

4.байгалийн бүс, бүслүүрийн онцлог, түүнд шүтэлцэн амьдрах биологийн олон янз байдлын үндсэн төлөөлөл болох амьд биес;

5.нүүдлийн мал аж ахуйд тулгуурласан байгаль хамгаалах уламжлалт мэдлэг, арга ухаан;

6.хүний үүсэл, хөгжил, хувьсал өөрчлөлтийн зүй тогтол;

ATA12932 6594204 9024070546

7.монголчуудын төрт ёс, түүх соёл, өв уламжлалын хосгүй нандин үнэт зүйл болсон монгол гэрийн оршихуйн цогц тогтолцоог байгалийн шинжлэх ухааны ололт, дижитал технологийн хүртэн мэдрэх аргаар тайлбарлан таниулах замаар байгаль, экологийн уламжлалт мэдлэг, арга ухааныг өвлөн уламжлуулж, түгээн дэлгэрүүлнэ.

Үзүүллэг, үзэсгэлэнгүүд нь шинжлэх ухааны баримт, нотолгоонд үндэслэсэн сан хөмрөгийн цуглуулга, байгалийн юмс, үзэгдлийг дуурайлган хийсэн үзмэр, орчин үеийн загвар, дижитал технологийн шийдэл, интерактив өгүүлэмжийг хослуулан дэлхийн шинжлэх ухааны хөгжлийн хандлагыг Монголын байгаль, нийгэм, соёлын өвтэй холбон тайлбарласан бүтэцтэй байна.

Үзүүллэгийн орон зайн төлөвлөлтөд олон шийдэлт дизайны зарчмыг баримталж, бүх насны, ялгаатай хэрэгцээ, шаардлагын онцлогийг тооцсон, мэдрэхүйн хэрэгцээнд нийцсэн, жендерийн мэдрэмжтэй, тэгш хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.

Түр болон нүүдлийн үзэсгэлэнгүүдийн агуулга нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил, биологийн олон янз байдлын хамгаалал зэрэг дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудад анхаарч, шийдэл, сайн туршлагыг санал болгох арга замаар олон улсын хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулахад чиглэнэ.

ДОЛОО. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ

Монгол орны байгаль орчны төлөв байдал, биологийн олон янз байдлын судалгаа, хамгааллын арга замыг онол, арга зүйн өндөр түвшинд боловсруулах, музейн үйл ажиллагаагаар дамжуулан бүх шатны сургалтын хөтөлбөрийн агуулгыг баяжуулан хүүхэд, залуучуудад олгох, соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулж, иргэдийн байгаль орчны талаарх мэдлэгийг тэлэх боловсрол, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн төвийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Музейн хөгжлийн бодлого "Хүний хөгжлийн орон зай" стратегийг баримтална.

Музей нь үндсэн үйл ажиллагаагаараа дамжуулан Монгол орныг олон улсад хил хязгааргүй нээлттэй сурталчлах замаар Монголын байгаль, нүүдлийн соёл, иргэншлийн орон зайн дэлхий дахины үнэлэмжийг өсгөхөд чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ үүрэг оролцоо Монголын түүх, соёл, байгалийн үнэт зүйлийг анхаарч сонирхох сонирхлын хүрээг өргөжүүлэн, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, Монгол судлалд оролцогчдын тоо хэмжээг өсөн нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Судалгаа, инновац, олон нийтийн оролцоог хослуулсан, шинэ үеэ татан оролцуулсан соёл, боловсрол, шинжлэх ухааны ирээдүй үед зориулсан музей байна.

Монгол орны байгалийн шинжлэх ухааны судалгаа өргөжиж, нийт иргэдийн байгалийн шинжлэх ухааны ойлголт мэдлэг, дадал, чадвар дээшилж,

ATA12932 6594204 9024070546

Монгол орныг зорин ирэх жуулчдын урсгал өсөн нэмэгдэж, уур амьсгалын өөрчлөлтийн үйл явцад нөлөөлж буй хүний буруутай үйл ажиллагааны шалтгаан нөхцөл буурах, байгаль хамгаалах уламжлалт мэдлэгийн оршин тогтнох чадвар сайжирч, ийм үзэл санаа хүртээмжтэй түгэн дэлгэрэх зэрэг чанарын эерэг үзүүлэлтүүд нь Байгалийн шинжлэх ухааны үндэсний музейн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлэх баримт болно.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.ДАВААЦЭРЭН

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч

О.МЭНДСАЙХАН

Байгалийн түүхийн музейн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, доктор (Ph.D)

Н.МАНЧУК

Соёлын өвийн үндэсний төвийн захирал, доктор (Ph.D)

Г.ЭНХБАТ

Чингис хаан үндэсний музейн захирал, Академич, доктор (Sc.D)

С.ЧУЛУУН

Шинжлэх ухааны академийн Палеонтологийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D)

З.БАДАМХАТАН

Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D)

Д.ГАНТУЛГА

Шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D)

А.ДАШЦЭРЭН

Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D)

И.ТҮВШИНТОГТОХ

Шинжлэх ухааны академийн Геологийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D)

С.ТӨРБОЛД

Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D)

Г.ЭРЭГЗЭН

Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D)

Л.ЭРДЭНЭБОЛД

Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D)

Ч.ОДОНБААТАР

Монгол Улсын Их сургуулийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан проректор, доктор (Ph.D)

С.ГОМБОБААТАР

Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн албаны дарга, доктор (Ph.D)

Ц.ЦОГГЭРЭЛ

Хөдөө аж ахуйн их сургуулийн Эрдэм шинжилгээ, гадаад харилцаа хариуцсан проректор, доктор (Ph.D)

Монгол Улсын Боловсролын их сургуулийн Биологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)

Соёл, урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн проректор, доктор (Ph.D)

ATA12932 659420

Э.ТӨМӨРТОГТОХ

Төв Азийн хөрс судлалын холбооны захирал, доктор (Ph.D)

Б.УНДРАХ-ОД

Ж.АРИУНБОЛД

Байгалийн түүхийн музейн Захиргаа, аж ахуйн хэлтсийн дарга, доктор (Ph.D)

Б.БАДАМЦЭЦЭГ

Ж.ЭРХЭМТӨГС

Байгалийн түүхийн музейн Эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Т.ТОДГЭРЭЛ

Байгалийн түүхийн музейн Маркетингийн менежер, доктор (Ph.D)

Ж.МЯНДАС

Байгалийн түүхийн музейн Үзүүллэг, үзэсгэлэнгийн хэлтсийн дарга

О.СОРОНЗОНБОЛД

Байгалийн түүхийн музейн Эрдэм шинжилгээний хэлтсийн дарга

Ж.МЯГМАРСҮРЭН

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн бодлого, төлөвлөлт, судалгаа хариуцсан шинжээч, доктор (Ph.D)

Ч.НАЦАГНЯМ

---oOo---